

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХАА	Хөдөө аж ахуй



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨӨГИЙН
ХӨГЖЛИЙН ТӨСЛИЙН НЭМЭЛТ
САНХҮҮЖИЛТ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Ж.ТҮВШИНСАНАА
ТАНАА

2020.05.01 № 06/1479
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ж.Түвшинсанаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын үр дүнд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлалд нийцсэн санхүүгийн програм хангамж ашиглан нягтлан бодох бүртгэл хөтөлж ажиллах, Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 09-нөөс 2020 оны 04 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, З.Дайриймаа нар хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-2019/032 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01-2020/095 дугаар бүхий албан бичгээр төлсийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Азийн Хөгжлийн Банк Монгол Улсын Засгийн Газартай 2015 оны 10 дугаар сарын 28-нд Зээлийн хэлэлцээрүүдийг тус тус байгуулж, АХБ-ны Тусгай сангийн нөөцөөс 10,719,000 Зээлжих Тусгай Эрхтэй тэнцэх хөрөнгө (ойролцоогоор \$15,000,000.0)-ийг төрөл бүрийн валютаар, Энгийн эх үүсвэрээс 35,000,000.0 ам.долларыг Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилтийг санхүүжүүлэх зорилгоор зээлдүүлэхийг зөвшөөрсөн. Зээлийн хэлэлцээр тус бүрийн дуусах хугацаа 2021 оны 06 дугаар сарын 30 байна.

Төслийн зорилго: Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байр бий болгох, Монгол Улсын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахад оршино. Төсөл нь дор дурдсан 4 үр дүн гаргах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

1. Нэмүү өртгийн сүлжээнд хөрөнгө оруулалт хийх;
2. Малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
3. ААН-дийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамжийг сайжруулах;
4. Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт.

Нэмүү өртгийн сүлжээнд хөрөнгө оруулалт хийх ажлын хүрээнд тайлант хугацаанд 10 компанид 25,826,000.0 мянган төгрөгийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл олгосон. Мөн малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамжийг сайжруулах, монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт 32 удаагийн сургалтыг төсөл хэрэгжиж буй аймаг, сумд болон Улаанбаатар хотод зохион байгуулсан бөгөөд эдгээрт 118 хүн хамрагдсан байна.

Тайлант хугацаанд 2,3,4 дүгээр ажлын хүрээнд нийт 31 арга хэмжээний 5,074,605.3 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа хийхээр төлөвлөснөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 4,568,486.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх болон зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, нийтдээ 3,901,765.2 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч,

ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төслийн нэгж нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх журам”-ын дагуу тайлан гаргах зориулалтаар боловсруулсан “Explorer 3.52” програм ашиглаж байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналтын тогтолцооны хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019

оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 118,101,287.2 мянган төгрөгөөс 2,362,025.7 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2,403,775.9 мянган төгрөг гэж авч үзсэн.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөл хэрэгжүүлэх нэгж нь АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг тул нийт хөрөнгөөс тооцох нь илүү оновчтой гэж үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,733,558.2 мянган төгрөгөөр буюу 32.87 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	30,011,532.0	22,728,603.4	(7,282,928.6)
Авлага	60,415,309.3	95,268,030.3	34,852,721.0
Бараа материал	13,319.2	7,525.1	(5,794.1)
Урьдчилж гарсан зардал		7,145.1	7,145.1
Бусад эргэлтийн хөрөнгө		2,167,874.3	2,167,874.3
Үндсэн хөрөнгө	175,835.4	175,835.4	-
Хуримтлагдсан элэгдэл	(160,759.6)	(166,219.1)	(5,459.5)
Нийт хөрөнгө	90,455,236.3	120,188,794.5	29,733,558.2
Богино хугацаат өр төлбөр	1,783,001.3	172,756.8	(1,610,244.5)
Урьдчилж орсон орлого	400,594.3	8,628.2	(391,966.1)
Урт хугацаат өр төлбөр	60,262,300.0	86,088,300.0	25,826,000.0
Хуримтлагдсан үр дүн	28,009,340.7	33,919,109.5	5,909,768.8
Өмнөх оны үр дүн	24,340,389.5	30,324,500.0	5,984,110.5
Тайлант оны үр дүн	3,668,951.2	3,594,609.5	(74,341.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	90,455,236.3	120,188,794.5	29,733,558.2

Мөнгөн хөрөнгө: Төсөл нь тайлант хугацааны эцэст ам.долларын дансдын үлдэгдэл 6,449,603.9 мянган төгрөг, төгрөгийн дансдын үлдэгдэл 14,711,490.7 мянган төгрөг нийт 22,728,603.4 мянган төгрөгийг тайлагнасан.

Авлага: Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зорилтын хүрээнд төсөл эхэлснээс хойш тайлант хугацааны эцсийн байдлаар 37 компанид олгосон зээлийн авлага 83,380,384.2 мянган төгрөг байна. Мөн эдгээр зээлийн хүүний авлагын үлдэгдэл 100,659.4 мянган төгрөг байна. Мөн Төрийн сан дахь 100900011606 тоот дансанд АХБ-ны эх үүсвэрийн мөнгө 11,786,986.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба уг мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татсан тул авлага үүсгэж тайлагнасан.

Урьдчилж гарсан зардал: Тайлант хугацаанд “Авто машины зогсоолын талбайг түрээслэх” гэрээний дагуу түрээслүүлэгч талд 1,200.0 мянган төгрөг, “Санхүүгийн програм

хангамж боловсруулан суурилуулах” гэрээний дагуу 5,945.1 мянган төгрөгийн урьдчилгааг тус тус төлсөнийг урьдчилж гарсан зардлаар тайлагнасан.

Бусад эргэлтийн хөрөнгө: Төслийн зорилгын хүрээнд 2,167,874.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материалыг худалдан авч захиалагч ХХААХҮЯ, ашиглагч буюу хүлээн авагч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн боловч захиалагч болон ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд тусгагдаагүй тул аудитаар уг 2,167,874.3 мянган төгрөгийн хөрөнгийг төслийн нэгжийн санхүүгийн байдлын тайланд бусад эргэлтийн хөрөнгөөр залруулан тайлагнасан.

Үндсэн хөрөнгө: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан тээврийн хэрэгсэл, компьютер, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд 5,459.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

Богино хугацаат өр төлбөр: Худалдан авах ажиллагааны гэрээний дагуу гүйцэтгэгчид төлөх барааны төлбөр 172,756.8 мянган төгрөгийг өр төлбөрөөр тайлагнасан.

Урьдчилж орсон орлого: Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээлийн хүүний илүү төлөлт 8,628.2 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор тайлагнасан.

Урт хугацаат өр төлбөр: АХБ-наас авсан дамжуулан зээлдүүлэх нөхцөлтэй зээлийн санхүүжилт нийт 86,088,300.0 мянган төгрөгийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан тайлант онд 35,186,894.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 31,542,536.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Төсвийн зардлын гүйцэтгэл 31,792,949.6 мянган төгрөг буюу 90.3 хувьтай байна. Үүнд төслийн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардал хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 2. Төслийн орлого

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	178,500.0	3,168,172.3	(2,989,672.3)	1,774.89
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	35,008,394.7	28,374,363.8	6,634,030.9	81.05
Нийт дүн	35,186,894.7	31,542,536.0	3,644,358.6	89.64

Хүснэгт 3. Төсвийн зардал

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардал	5,714,413.9	2,461,791.1	3,252,622.8	43.08
Хөрөнгийн зардал	3,642,480.8	3,505,158.5	137,322.3	96.23
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	25,830,000.0	25,826,000.0	4,000.0	99.98
Нийт дүн	35,186,894.7	31,792,949.6	3,393,945.1	90.35

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан төсвийн хүрээнд зүй зохистой зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,271,159.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,271,159.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгыг хийв. Үүнд:

- Түрээслүүлэгч талд урьдчилж төлсөн авто зогсоолын түрээсийн төлбөр 1,200.0 мянган төгрөг, гүйцэтгэгч талд төлсөн санхүүгийн програм боловсруулан суурилуулах ажлын урьдчилгаа 5,945.1 мянган төгрөгийг тус тус тайлант хугацааны зардлаар бүртгэсэн байна. Энэ нь “тасалбар болголт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүйгээс гадна НББОУС1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлэг "6.1. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцээгүй байна.
- Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу хүлээн зөвшөөрөх хүүний орлогыг 96,140.3 мянган төгрөгөөр илүү, хүүний авлагыг 87,512.1 мянган төгрөгөөр илүү, урьдчилж орсон хүүний орлогыг 8,628.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна. Энэ нь “үнэн зөв” батламж мэдэгдлийг хангаагүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлэг "5.1.4 Үнэн зөв байх" гэсэн зарчимтай нийцээгүй байна.
- Төслийн зорилгын хүрээнд 2,167,874.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материалыг худалдан авч захиалагч тал болох ХХААХҮЯ, ашиглагч буюу хүлээн авагч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн. Эдгээр хөрөнгүүд нь төсөл хэрэгжүүлэгч нэгж, захиалагч, ашиглагч байгууллагуудын санхүүгийн байдлын тайланд тусгагдаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага тул нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл сууриар бүртгэхтэй холбоотойгоор олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах, хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр худалдан авч буй байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл

дуусахад төрийн өмчид шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүгийн өр төлбөрийг хэрхэн авч үзэх;

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;
- Төслийн зорилгын хүрээнд 2,167,874.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материалыг худалдан авч захиалагч тал болох ХХААХҮЯ, ашиглагч буюу хүлээн авагч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн. Эдгээр хөрөнгүүд нь төсөл хэрэгжүүлэгч нэгж, захиалагч, ашиглагч байгууллагуудын санхүүгийн байдлын тайланд тусгагдаагүй байсан тул аудитын залруулгаар эдгээр хөрөнгийг төслийн санхүүгийн байдлын тайланд бусад эргэлтийн хөрөнгөөр тайлагнасан тул дараагийн аудитаар тус хөрөнгүүдийг захиалагч болон ашиглагч байгууллагуудад шилжүүлэн бүртгэсэн эсэхийг хянах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 148 мэдээллийг оруулахаас 139 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж дуусаагүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн програм хангамжийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх журам”-ын дагуу боловсруулсан “Axplorer 3.52” програмыг тайлант оны сүүлээс эхлэн ашиглаж байна. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу АХБ-нд хүргүүлдэг тайлан, мэдээнүүдийг нэмэлт модуль болгон уг програмд боловсруулалт хийж байгаа ба програмыг хараахан бүрэн хэмжээнд ашиглаж эхлээгүй байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал буруу, алдаатай бэлтгэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүгийн програмыг Нягтлан бодох бүртгэлийн хууль, УСНББОУС-ын шаардлагад нийцүүлсэн байдлаар шинэчлэх, холбогдох өөрчлөлтийг оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өмнөх аудитаар санхүүгийн програмтай болох зөвлөмж өгсөн. Тайлант оны сүүлээр АХБ-аас санхүүгийн эх үүсвэрийг шийдүүлж төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөж, тайланг бэлтгэдэг програм хангамж худалдан авч уг програм дээр АХБ-нд хүргүүлдэг тайлангийн мэдээнүүдийг нэмэлт модуль болгон оруулах ажил хийгдэж байна. Одоогоор төслийн нэгж нь төслийн нягтлан болох бүртгэл хөтлөлтөнд уг програмыг ашиглахаас гадна “Майкрософт эксэл” програмыг давхар ашиглаж байна.

3.2 Шилэн дансны мэдээллийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 148 мэдээллийг оруулахаас 139 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих; мэдээлэл буруу орох.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэд оруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төслийн нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн гүйцэд оруулж ажиллаж байна. Шилэн дансанд мэдээлэл оруулж байх үед систем гацах, мэдээлэл хадгалагдахгүй байх зэрэг алдаа гардаг. Мөн хугацаандаа оруулсан мэдээллийг шинэчилж үг үсэг, дугаар, хавсралт файл гэх мэт техник засвар оруулах, өмнө нь баталгаажуулсан мэдээллийг хуулбарлан татахдаа санамсаргүйгээр “засах”, “хадгалах” товч дарахад шууд хугацаа хоцорсон ангилалд ордог. Мөн “Байгууллагын батлагдсан төсөв”-ийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор оруулах ёстой боловч УИХ-аар батлагдсан төсөв Сангийн яамнаас 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр албажиж ирсэн тул ирүүлсэн төсвийг шинэчилж оруулахад шилэн дансны систем дээр хугацаа хоцорсон гэсэн ангилалд бүртгэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,440,160,649.39	120,179,178,278.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,011,532,068.30	22,728,603,403.39
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	26,934.06	26,855.06
31110	Кассанд байгаа бэлэн мөнгө (төгрөг)	26,934.06	26,855.06
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,011,505,134.24	22,728,576,548.33
31210	Төгрөг	14,335,565,472.81	16,278,972,674.99
31211	Төрийн сангийн харилцах		1,567,508,761.85
31213	Арилжааны банк дахь харилцах	14,335,565,472.81	14,711,463,913.14
31220	Гадаад валют	15,675,939,661.43	6,449,603,873.34
31223	Арилжааны банк дахь харилцах	15,675,939,661.43	6,449,603,873.34
33	АВЛАГА	60,415,309,333.59	95,268,030,329.85
33300	Татаас санхүүжилтийн авлага		11,786,986,762.28
33400	Зээлийн хүүгийн авлага	0.00	100,659,362.99
33500	Бусад авлага	290,509,499.21	0.00
33501	Байгууллагаас авах авлага	290,509,499.21	0.00
33600	Зээлийн авлага	60,124,799,834.38	83,380,384,204.58
33615	Аж ахуйн нэгжид олгосон зээл	60,124,799,834.38	83,380,384,204.58
34	УРЬДЧИЛГАА		7,145,082.00
34710	Урьдчилгаа тооцоо		7,145,082.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,319,247.50	7,525,144.83
35400	Хангамжийн материал	13,319,247.50	7,525,144.83
35410	Бичиг хэргийн материал	2,353,650.83	1,125,000.00
35420	Аж ахуйн материал		482,910.00
35430	Сэлбэг хэрэгсэл		466,000.00
35440	Түлш, шатахуун тослох материал	10,965,596.67	4,849,584.83
35470	Бусад хангамжийн материал		601,650.00
36	БУСАД ХӨРӨНГӨ		2,167,874,318.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад		2,167,874,318.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,075,726.55	9,616,258.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,075,726.55	9,616,258.87
39200	Биет хөрөнгө	15,075,726.55	9,616,258.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,572,198.49	104,572,198.49
39204	Хуримтлагдсан элэгдэл	(104,572,198.49)	(104,572,198.49)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	60,598,433.14	60,598,433.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,522,706.59)	(50,982,174.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,939,409.23	1,939,409.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,939,409.23)	(1,939,409.23)
39300	Биет бус хөрөнгө	0.00	0.00
39301	Програм хангамж	8,725,324.59	8,725,324.59
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,725,324.59)	(8,725,324.59)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	90,455,236,375.94	120,188,794,536.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	62,445,895,649.66	86,269,685,038.69

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,183,595,649.66	181,385,038.69
41320	Бараа, үйлчилгээний зардлын өглөг	1,783,001,355.00	172,756.800.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	400,594,294.66	8,628,238.69
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60,262,300,000.00	86,088,300,000.00
42211	ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөв	60,262,300,000.00	86,088,300,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,009,340,726.28	33,919,109,498.25
51	Засгийн газрын хувь оролцоо	28,009,340,726.28	33,919,109,498.25
51200	Хуримтлагдсан үр дүн	28,009,340,726.28	33,919,109,498.25
51210	Өмнөх үеийн үр дүн	24,340,389,523.94	30,324,500,011.09
51220	Тайлант үеийн үр дүн	3,668,951,202.34	3,594,609,487.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	90,455,236,375.94	120,188,794,536.94

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	30,551,038,314.47	31,600,436,719.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,551,038,314.47	28,381,764,826.19
120	Нийтлэг татварын бус орлого	28,542,231,153.65	25,163,125,039.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,542,231,153.65	25,163,125,039.34
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,231,208,000.25	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,827,137.34	6,988,148.81
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	25,305,196,016.06	25,155,691,861.70
120009	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		445,028.83
124	Хаагдсан данс	2,008,807,160.82	3,218,639,786.85
140003	Хаагдсан данс	2,008,807,160.82	3,218,639,786.85
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	3,218,671,893.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	3,218,671,893.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	0.00	3,218,671,893.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,553,840,784.93	4,781,169,944.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,463,810,006.89	3,181,128,944.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,463,810,006.89	2,466,344,599.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,783,001,355.00	
210105	Гэрээт ажлын хөлс	1,783,001,355.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,912,160.00	19,527,750.00
210201	Тэтгэврийн даатгал	17,912,160.00	19,527,750.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,903,782.00	104,699,340.00
210304	Байрны түрээс	104,903,782.00	104,699,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,137,030.18	40,245,279.80
210401	Бичиг хэрэг	16,559,625.34	13,672,360.13
210402	Тээвэр, шатахуун	7,833,403.33	21,396,074.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,744,001.51	5,176,845.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,123,545.00	18,126,910.00
210604	Урсгал засвар	22,123,545.00	18,126,910.00
2107	Томилолт, зочны зардал	12,938,400.00	18,249,500.00
210702	Дотоод албан томилолт	12,938,400.00	18,249,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	631,894,726.49	702,948,477.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	631,894,726.49	702,948,477.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,857,899,008.22	1,562,547,342.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,852,618,779.75	1,557,087,875.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,280,228.47	5,459,467.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		714,784,345.01
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		6,988,148.81
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		6,988,148.81

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		707,796,196.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		707,796,196.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	90,030,778.04	1,600,041,000.00
222001	Хаагдсан данс	90,030,778.04	1,600,041,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	25,997,197,529.54	26,819,266,774.35
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,356,753,672.80	2,601,497,337.06
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,356,753,672.80	391,151,289.92
145003	Хөрөнгө оруулалтын олз		2,210,346,047.14
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,685,000,000.00	25,826,154,624.25
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		154,624.25
225006	Хаагдсан данс	23,685,000,000.00	25,826,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,668,951,202.34	3,594,609,487.16

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	30,787,996,434.82	28,330,852,308.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,787,996,434.82	28,330,852,308.21
120	Нийтлэг татварын бус орлого	30,787,996,434.82	28,330,852,308.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,787,996,434.82	28,330,852,308.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,260,965,812.26	3,168,172,297.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,827,137.34	6,988,148.81
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	25,521,203,485.22	25,155,691,861.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,399,340,266.22	14,963,562,189.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,399,340,266.22	14,963,562,189.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,399,340,266.22	2,461,791,082.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		19,527,750.00
210201	Тэтгэврийн даатгал		19,527,750.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,903,782.00	104,699,340.00
210304	Байрны түрээс	104,903,782.00	104,699,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,426,962.37	31,654,674.30
210401	Бичиг хэрэг	18,582,707.17	12,617,829.30
210402	Тээвэр, шатахуун	18,799,000.00	13,860,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,644,001.51	5,176,845.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,401,253.69	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,123,545.00	19,792,910.00
210604	Урсгал засвар	22,123,545.00	19,792,910.00
2107	Томилолт, зочны зардал		18,249,500.00
210702	Дотоод албан томилолт		18,249,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	665,845,286.49	705,508,214.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	665,845,286.49	705,508,214.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	554,040,690.36	1,562,358,694.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	554,040,690.36	1,562,358,694.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		12,501,771,107.29
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		11,793,974,911.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,786,986,762.28
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		6,988,148.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		707,796,196.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		707,796,196.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,388,656,168.60	13,367,290,118.27
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		5,071,116,551.90
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт		5,071,116,551.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	95,407,957.29	286,486,625.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	95,407,957.29	286,486,625.00
2200	Дотоод эх үүсвэрээр	95,407,957.29	286,486,625.00

222001	Тоног төхөөрөмж	90,030,778.04	165,697,625.00
223001	Бусад хөрөнгө		120,789,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,377,179.25	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(95,407,957.29)	4,784,629,926.90
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(23,678,597,710.70)	(25,434,848,710.08)
14	Бусад эх үүсвэр	1,340,802,297.80	391,151,289.92
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,340,802,297.80	391,151,289.92
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	25,019,400,008.50	25,826,000,000.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	25,019,400,008.50	25,826,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,614,650,500.61	(7,282,928,664.91)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,396,881,567.69	30,011,532,068.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,011,532,068.30	22,728,603,403.39

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл			24,340,389,523.94	24,340,389,523.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
9	Тайлант үеийн үр дүн			3,668,951,202.34	3,668,951,202.34
10	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл			28,009,340,726.28	28,009,340,726.28
11	2019 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл			28,009,340,726.28	28,009,340,726.28
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,315,159,284.81	2,315,159,284.81
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			30,324,500,011.09	30,324,500,011.09
19	Тайлант үеийн үр дүн			3,594,609,487.16	3,594,609,487.16
20	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	33,919,109,498.25	33,919,109,498.25

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,186,894,700.00	31,792,949,600.65	3,393,945,099.35	90.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,714,413,900.00	2,461,791,082.65	3,252,622,817.35	43.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,714,413,900.00	2,461,791,082.65	3,252,622,817.35	43.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,570,000.00	19,527,750.00	4,042,250.00	82.85
210201	Тэтгэврийн даатгал	23,570,000.00	19,527,750.00	4,042,250.00	82.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,912,700.00	104,699,340.00	3,213,360.00	97.02
210304	Байрны түрээс	107,912,700.00	104,699,340.00	3,213,360.00	97.02
2104	Хангамж, бараа материалын зардал	56,863,000.00	31,654,674.30	25,208,325.70	55.67
210401	Бичиг хэрэг	20,160,000.00	12,617,829.30	7,542,170.70	62.59
210402	Тээвэр, шатахуун	20,160,000.00	13,860,000.00	6,300,000.00	68.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,636,000.00	5,176,845.00	1,459,155.00	78.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,907,000.00	0.00	9,907,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,240,000.00	19,792,910.00	3,447,090.00	85.17
210604	Урсгал засвар	23,240,000.00	19,792,910.00	3,447,090.00	85.17
2107	Томилолт, зочны зардал	99,078,000.00	18,249,500.00	80,828,500.00	18.42
210702	Дотоод албан томилолт	99,078,000.00	18,249,500.00	80,828,500.00	18.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,690,430,200.00	705,508,214.25	2,984,921,985.75	19.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,690,430,200.00	705,508,214.25	2,984,921,985.75	19.12
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,713,320,000.00	1,562,358,694.10	150,961,305.90	91.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,713,320,000.00	1,562,358,694.10	150,961,305.90	91.19
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,642,480,800.00	3,505,158,518.00	137,322,282.00	96.23
222001	Тоног төхөөрөмж	2,232,063,400.00	2,232,063,318.00	82.00	100.00
223001	Бусад хөрөнгө	1,410,417,400.00	1,273,095,200.00	137,322,200.00	90.26
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	25,830,000,000.00	25,826,000,000.00	4,000,000.00	99.98
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	25,830,000,000.00	25,826,000,000.00	4,000,000.00	99.98

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,186,894,700.00	31,542,536,052.40	3,644,358,647.60	89.64
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,186,894,700.00	31,542,536,052.40	3,644,358,647.60	89.64
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	178,500,000.00	3,168,172,297.70	(2,989,672,297.70)	1774.89
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	35,008,394,700.00	28,374,363,754.70	6,634,030,945.30	81.05
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	18,224,545,306.02	(18,224,545,306.02)	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	22,337,452,113.47	(22,337,452,113.47)	0.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО		11		
620001	Удирдах ажилтан		2		
620002	Гүйцэтгэх ажилтан		2		
620003	Үйлчлэх ажилтан		3		
620004	Гэрээт ажилтан		4		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020.04.27			САГ-2020/726/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төсөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөн гөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	<p>Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх журам”-ын дагуу боловсруулсан “Axplorer 3.52” програмыг тайлант оноос эхлэн ашиглаж байна. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу уг програм дээр АХБ-нд хүргүүлдэг тайлан, мэдээнүүдийг нэмэлт модуль болгон уг програмд боловсруулалт хийж байгаа ба програмыг хараахан бүрэн хэмжээнд ашиглаж эхлээгүй байна.</p> <p>Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.</p>	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Ж.Түвшинсанаа
2	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 148 мэдээллийг оруулахаас 139 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Ж.Түвшинсанаа
	Зөвлөмжийн дүн	-			

